



МОНГОЛ УЛС  
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2022 оны 03 сарын 04 өдөр

Дугаар А/105

Ховд

Нийтийн тээвэрт дэмжлэг үзүүлэх тухай


Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны “Аймгийн 2022 оны төсөв батлах тухай” 05/07 дугаар тогтоолын 12 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. “Бат хөсөгтөн” ХХК-ийн автобусны паркад шинэчлэл хийж үйлчилгээнд том оврын автобусаар үйлчилгээг өргөтгөсөн, шатахууны үнийн өсөлтийг үндэслэн Жаргалант сумын иргэдийн нийтийн тээврийн үйлчилгээний хүртээмжийг сайжруулах зорилгоор 15,000,000 төгрөг (арван таван сая)-ийн санхүүгийн дэмжлэгийг баталж олгосугай.

2. Санхүүгийн дэмжлэгт олгох 15,000,000 төгрөгийг аймгийн барьцаа дансанд аймгийн замын сангийн 2021 оны төвлөрүүлсэн орлогоос санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга (Б.Баярсүх), Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (Ч.Багдал) нарт зөвшөөрсүгэй.

3. Санхүүгийн дэмжлэгийн дагуу Жаргалант сумын алслагдсан багуудын иргэдийн нийтийн тээврийн үйлчилгээг тогтмолжуулан, хүртээмжийг сайжруулах арга хэмжээ авч ажиллахыг Жаргалант сумын Засаг дарга /Ц.Цогтбаяр/-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ

8400 07 0549

Zah A/105 Kh